
БАЯН ТАЛ
ГОВЬСҮМБЭР
МЭДЭЭЛЭЛ
2024.09.23

- Сумын Засаг даргын орлогч, Лүн багийн Засаг дарга нар хадланчдынхаа хүсэлтээр хадлан хадаж буй газарт очиж ажиллаа.





- 14-зөрлөгийн урд хэсэгт нойл, хогийн сав орчмийн хог
- 16-р зөрлөгийн зам дагуу байгаа хогийг цэвэрлэж ажилласан.









Дэлгүүр, соёлын төв хоорондох гудамжны гэрэлтүүлгийн кабель тасарсаныг засаж эмнэлгийн зүгт явсан гэрэлтүүлэг хэвийн болгосон.





Баянтал сумын Хөдөлмөр, халамж  хариуцсан шинэ мэргэжилтэнтэй болсны дагуу аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас хүмүүс ирж амьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд сургалт зохион байгуулан ажилласан.



Баянтал суманд аймаг, сумын ахмадын хороо, Орхон аймгийн ахмадын хорооны төлөөллүүдийг хүлээн авч нөхөрсөг уулзалтыг зохион байгуулсан.





Говьсүмбэр аймгийн “Намрын ногоон өдрүүд” шилмэл мал- шилдэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаа 2024 оны 09 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.

Баянтал сумаас “МАЖӨТ малчид”-н хоршоо, Улсын аварга малчин Г.Мөнхбаяр, Аймгийн аварга малчин Г.Баярмагнай, сумын аварга малчин Р.Манлайсүрэн, залуу малчин Б.Нямсүрэн, Б.Ширчинжав нар шилдэг хээлтүүлэгчийн төрлөөр, мөн малчин Б.Ширчинжав айргаар оролцлоо.

Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 2023 оны шилдэг үйлдвэрлэгч тэргүүн байрын шагналт Х.Мөнх-Эрдэнэ, дэд байрын шагналт Ж.Гэсэржав нар оролцлоо.






Азарга Тэргүүн байр: аймгийн аварга малчин Г.Баярмагнайн “Хүрэн” азарга



Азарга Дэд байр :Залуу малчин Б.Нямсүрэнгийн “Халтар азарга



- <u>Бух дэд байр</u>: Улсын аварга малчин Г.Мөнхбаярын “Улаан халзан” Грефорд үүлдрийн бух
- <u>Бух гутгаар байр</u>: Залуу малчин Б.Нямсүрэнгийн “Хүрэн халзан” бух
- <u>Хуц дэд байр</u>: Улсын аварга малчин Г.Мөнхбаярын “Улаан хүзүүт” Барга үүлдрийн хуц
- <u>Хуц гутгаар байр</u>: Г.Мөнхбаярын “Шар толгойт” Барга үүлдрийн хуц









- “МАЖӨТ малчид” хоршоо шилдэг бүлгээр шалгарч аймгийн ХХААГазрын хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан.


Өргөмжлөл

Эрхэм хүндэт МАЖӨТ хоршоо бүлэгт

Намрын ногоон өдрүүд "ШИЛМЭЛ МАЛ-2024" үзэсгэлэн худалдаанд идэвхи санаачлага гарган хамгийн олон мал оролцуулсан тул "ШИЛДЭГ БҮЛЭГ"-ээр шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.

2024

- Газар тариалангийн шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр : Лүн багийн иргэн Х.Мөнх-Эрдэнэ нь 2 дах жилдээ тэргүүн байр эзэлж Шилдгийн шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр шалгарсан






# Цэцэрлэг

Томуугийн вакцинд 2-5 насны 3 бүлгийн 44 хүүхэд хамрагдсан Улаан бурхан, улаануудын вакциныг 11 ажилчин хийлгэсэн Урьдчилан сэргийлэх үзлэгт 65 хүүхэд, 9 багш, туслах багш, ажилчид хамрагдсан. .

Хүүхдийн дархлааг дэмжих зорилготойгоор байгууллагын үйлдвэрчний эвлэлийн санхүүжилтээр 3 бүлгийн 65 хүүхдэд витаминжуулалт хийж байна.







Төв хогийн цэгийн хашааны гадна талд тарсан хогийг тамгын газрын төрийн үйлчилгээний ажилчид түүж бөөгнүүлэн хогийн цэгт төвлөрүүллээ.





Сумын Засаг даргаар ахлуулсан баг хөдөө малчдаараа тойрч өвөлжилтийн бэлтгэл ажил, сумаас хийж хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, иргэд малчдынхаа санал хүсэлтийг сонсож явна








Баянтал Эрүүл Мэндийн Төв-ийн хамт олон өөрсдийн нөөц боломцоогоор эрүүл мэндийн төвийн дотор болон гадаад өнгө үзэмжийг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.








ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЯНТАЛ СУМ**

# Анхаарал хандуулсанд баярлалаа

WWW.BAYANTAL.GS.GOV.MN